



БАЯНХОНГОР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СТАТИСТИКИЙН ТАНИЛЦУУЛГА

Баянхонгор аймгийн эдийн
засаг, нийгмийн байдал

Энэ удаагийн дугаарыг эрхлэн гаргасан Хэлтсийн ахлах мэргэжилтэн Х.Оюунчимэг

**ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
2017 ОНЫ 01 САРЫН ТАНИЛЦУУЛГА**



ХҮН АМЫН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Тус аймагт 2016 оны эцсийн байдлаар 833 хүн шилжин ирж сууришсан бөгөөд нийт ирсэн хүний 53.4 хувь нь эрэгтэйчүүд байжээ. Нийт шилжиж ирсэн хүнийг байршилаар нь авч үзвэл 71.3 хувь нь Улаанбаатар хотоос, 28.7 хувь нь бусад аймагаас ирсэн байна.

Харин 2016 оны эцсийн байдлаар нийт 1444 хүн өөр аймаг, нийслэл рүү шилжиж явсан бөгөөд нийт явсан иргэдийн 50.1 хувь эрэгтэйчүүд байжээ. Шилжиж явсан иргэдийг байршилаар нь авч үзвэл 79.3 хувь нь Улаанбаатар хотруу, 20.7 хувь нь бусад аймаг руу шилжиж явжээ.

Үүнээс харахад хүн амын ердийн механик өсөлт -611 болжээ. Өмнөх оны мөн үеэс 458 хүнээр буурсан байна.

Нийгмийн зарим үзүүлэлт

2016 оны эцсийн байдлаар 111 бүтэн өнчин хүүхэд байгаагийн 46.8 хувь нь буюу 52 хүүхэд нь эмэгтэй байна. Бүтэн өнчин хүүхдийн насны бүлэгээр авч үзвэл 0-15 насны 70, 16-17 насны 41 хүүхэд байна.

Харин жилийн эцсийн байдлаар 1535 хагас өнчин хүүхэд байгаагийн 48.4 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Хагас өнчин хүүхдийг насны бүлэгээр харвал 0-15 насныхан 76.7 хувийг, 16-17 насныхан 23.3 хувийг эзлэж байна.

Мөн 2016 эцсийн байдлаар өрх толгойлсон 5332 эх, эцэг байгаагийн 76.1 хувь нь өрх толгойлсон эхчүүд байна. Харин 18 хүртлэх насны хүүхэдтэй өрх толгойлсон 2553 эх, эцэг байгаагийн 84.4 хувь нь эхчүүд байна. Ганц биеэрээ амьдарч буй ахмад настан 1810 байгаагийн 78.6 хувь нь буюу 1423 нь 55 түүнээс дээш настай эмэгтэйчүүд байна.

2016 онд тус аймагт хөгжлийн бэрхшээлтэй 3416 хүн байгаагийн 44.0 хувь эмэгтэйчүүд, 6.3 хувийг 0-14 насны хүүхэд, 1.7 хувийг 15-17 насны хүүхэд тус тус эзлэж байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 44.9 хувь төрөлхий, 55.1 хувь нь олдмол төрөлтэй байна. Олдмол хөгжлийн бэрхшээлийг дотор нь задлаж үзвэл ердийн өвчин 1284, мэргэжилээс шалтаалсан өвчин 97, зам тээврийн осол 155, үйлдвэрийн осол 62, ахуйн осол 284 байна.

Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр авч үзвэл:

Харааны 406, ярианы 116, сонсголын 257, хөдөлгөөний 824, сэтгэцийн 686, хавсарсан 269, бусад 858 хүн байна. Мөн байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүн 449, үүнээс 0-17 насны хүүхэд 83 байна. Тэргэнцэртэй 36 хүн байгаагийн 0-17 насны 6 хүүхэд байжээ. Сургуульд суралцдаггүй хөгжлийн бэрхшээлтэй 94 хүүхэд, хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй 1003 хүн, хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй 2093 хүн тус тус байна.

ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

| Үзүүлэлт | м/д | Бүгд |
|--|-----|------|
| Ихэр хүүхэдтэй өрхийн тоо | 1 | 248 |
| 2 ихэр хүүхдийн тоо | 2 | 498 |
| 3 ихэр хүүхдийн тоо | 3 | 3 |
| 18 хүртлэх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо | 4 | 1588 |
| 4 хүүхэдтэй өрхийн тоо | 5 | 1508 |
| 5 хүүхэдтэй өрхийн тоо | 6 | 564 |
| 6 хүүхэдтэй өрхийн тоо | 7 | 617 |
| 7, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо | 8 | 354 |
| 6, түүнээс дээш гишүүнтэй өрхийн тоо | 9 | 2198 |
| Ганц биеэрээ амьдарч буй ахмад настай өрхийн тоо | 10 | 1810 |
| 60, тоонээс дээш настай эрэгтэй | 11 | 387 |
| 55, түүнээс дээш настай эмэгтэй | 12 | 1423 |
| Тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй амхад настай хүний тоо | 13 | 4 |
| 60, тоонээс дээш настай эрэгтэй | 14 | 2 |
| 55, түүнээс дээш настай эмэгтэй | 15 | 2 |

ӨНЧИН ХҮҮХДИЙН
ТОО, насны бүлэг

| | Бүгд | 0--4 | 5--9 | 10--14 | 15 | 16 | 17 |
|-------------|------|------|------|--------|----|----|----|
| Бүтэн өнчин | 49 | | 7 | 15 | 10 | 8 | 9 |
| эмэгтэй | 21 | | 2 | 7 | 5 | 5 | 2 |
| Хагас өнчин | 669 | 90 | 138 | 193 | 84 | 79 | 85 |
| эмэгтэй | 373 | 46 | 72 | 101 | 58 | 47 | 49 |

ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ /ЭЦЭГ/,
гишүүдийн тоо

| | Бүгд | 3 хүртэлх | 3--5 | 6 дүүнээс дээш |
|----------------|------|-----------|------|----------------|
| Өрх толгойлсон | 2357 | 1512 | 693 | 152 |
| эх | 1999 | 1318 | 579 | 102 |
| эцэг | 358 | 194 | 114 | 50 |

АРВАН НАЙМ ХҮРТЛЭХ НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХ
ТОЛГОЙЛСОН ЭХ /ЭЦЭГ/, хүүхдийн тоо

| | Бүгд | 3 хүртэлх | 3--5 | 6 дүүнээс дээш |
|---------------------------------|------|-----------|------|----------------|
| 18 хүртэлх насны Өрх толгойлсон | 1744 | 1294 | 348 | 102 |
| эх | 1500 | 1159 | 273 | 68 |

| | | | | |
|------|-----|-----|----|----|
| эцэг | 244 | 135 | 75 | 34 |
| | | | | |

5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, төрөл, хэлбэр, хүйсээр

| Үзүүлэлт | | | м/д | Бүгд | Эмэгтэй | Хөгжлийн бэрхшээлийн төрөл | | | | | | |
|--------------------------------|--------------|--------------|--------------|------|---------|----------------------------|--------------|------------------------------|-------------------|-----------------|------------|---|
| | | | | | | Төрөлхийн | Олдмол | | | | | |
| | | | | | | | Өвчнөөр | | Осол гэмтлээр | | | |
| | | | | | | | Ердийн өвчин | Мэргэжлээс шалтгаалсан өвчин | Зам тээврийн осол | Үйлдвэрийн осол | Ахуйн осол | |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо | | | 1 | 3416 | 1502 | 1534 | 1284 | 97 | 155 | 62 | 284 | |
| | Хүүхдийн тоо | 0-14 настай | 2 | 215 | 94 | 185 | 19 | | 4 | | 7 | |
| | | 15-17 настай | 3 | 57 | 27 | 48 | 7 | | | | 2 | |
| Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр | Харааны | | 4 | 406 | 145 | 207 | 142 | 6 | 5 | 4 | 42 | |
| | | Хүүхдийн тоо | 0-14 настай | 5 | 14 | 7 | 12 | 1 | | | | 1 |
| | | | 15-17 настай | 6 | 12 | 7 | 10 | 1 | | | | 1 |
| | Ярианы | | 7 | 116 | 48 | 98 | 15 | | 3 | | | |
| | | Хүүхдийн тоо | 0-14 настай | 8 | 18 | 5 | 16 | 2 | | | | |
| | | | 15-17 настай | 9 | 10 | 3 | 10 | | | | | |
| | Сонсголын | | 10 | 257 | 122 | 178 | 61 | 4 | 2 | 1 | 11 | |
| | | Хүүхдийн тоо | 0-14 настай | 11 | 15 | 6 | 15 | | | | | |
| | | | 15-17 настай | 12 | 5 | 4 | 5 | | | | | |
| | Хөдөлгөөний | | 13 | 824 | 326 | 351 | 243 | 14 | 93 | 19 | 104 | |
| | | Хүүхдийн тоо | 0-14 настай | 14 | 51 | 25 | 43 | 5 | | 2 | | 1 |
| | | | 15-17 настай | 15 | 9 | 5 | 5 | 3 | | | | 1 |
| | Сэтгэцийн | | 16 | 686 | 348 | 458 | 167 | 6 | 14 | 8 | 33 | |
| | | Хүүхдийн тоо | 0-14 настай | 17 | 40 | 17 | 35 | 4 | | 1 | | |
| 15-17 настай | | | 18 | 7 | 3 | 7 | | | | | | |
| Хавсарсан | | 19 | 269 | 138 | 74 | 139 | 20 | 8 | 4 | 24 | | |

| | | | | | | | | | | | |
|--|----------------------------|--------------|----|------|------|------|------|----|-----|----|-----|
| | Хүүхдийн тоо | 0-14 настай | 20 | 27 | 11 | 27 | | | | | |
| | | 15-17 настай | 21 | 6 | 2 | 4 | 2 | | | | |
| Бусад | | | 22 | 858 | 375 | 168 | 517 | 47 | 30 | 26 | 70 |
| | Хүүхдийн тоо | 0-14 настай | 23 | 50 | 23 | 37 | 7 | | 1 | | 5 |
| | | 15-17 настай | 24 | 8 | 3 | 7 | 1 | | | | |
| Тэргэнцэртэй хүний тоо | | | 25 | 36 | 13 | 12 | 15 | 1 | 2 | | 6 |
| | Хүүхдийн тоо | 0-14 настай | 26 | 4 | | 4 | | | | | |
| | | 15-17 настай | 27 | 2 | 1 | 1 | 1 | | | | |
| Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо | | | 28 | 449 | 212 | 245 | 152 | 3 | 16 | 1 | 32 |
| | Хүүхдийн тоо | 0-14 настай | 29 | 70 | 32 | 64 | 4 | | 1 | | 1 |
| | | 15-17 настай | 30 | 13 | 7 | 12 | 1 | | | | |
| Тэтгэвэр тэтгэмж тогтоолгосон хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо | | | 31 | 3265 | 1417 | 1474 | 1208 | 96 | 151 | 59 | 277 |
| Сургуульд суралцдаггүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо | | | 32 | 94 | 36 | 85 | 5 | | 2 | | 2 |
| Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо | | | 33 | 1003 | 402 | 284 | 573 | 19 | 26 | 10 | 91 |
| | Тэтгэврийн насны хүний тоо | | 34 | 72 | 39 | 33 | 33 | | 1 | | 5 |
| Хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо | | | 35 | 2093 | 972 | 1133 | 603 | 68 | 117 | 51 | 121 |



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Баянхонгор аймгийн мал 2016 онд 4 236 321 болж өмнөх оноос 12.3 хувиар буюу 464 454 толгойгоор өсчээ. Аймгийн дүнгээр мал таван төрөл дээрээ өссөн байна. Нийт малыг сүргийн бүтцээр нь авч үзвэл адуу 3.6 хувь, үхэр 5.1 хувь, тэмээ 1.2 хувь, 29.5 хувь хонь, ямаа 60.6 хувийг тус тус эзлэж байна. Өлзийтөөс бусад 19 сум малаа 7.4-24.6 хувиар өсгөсөн байна.

2016 ОНЫ НИЙТ МАЛ /ТАВАН ТӨРӨЛ/

| Сум/дүүрэг | Бүгд | Адуу | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
|-----------------|---------|--------|--------|--------|---------|---------|
| Баянхонгор сум | 169 373 | 7 284 | 22 381 | 212 | 55 301 | 84 195 |
| Баацагаан сум | 357 184 | 9 433 | 7 490 | 2 872 | 71 802 | 265 587 |
| Баянбулаг сум | 116 501 | 4 445 | 6 624 | 9 | 61 140 | 44 283 |
| Баянговь сум | 209 971 | 4 015 | 1 180 | 3 753 | 27 585 | 173 438 |
| Баянлиг сум | 223 050 | 4 009 | 1 380 | 19 922 | 34 173 | 163 566 |
| Баян-Овоо сум | 250 576 | 8 456 | 7 227 | 425 | 121 238 | 113 230 |
| Баян-Өндөр сум | 187 044 | 1 910 | 408 | 4 331 | 27 371 | 153 024 |
| Баянцагаан сум | 261 749 | 4 727 | 1 858 | 1 675 | 62 842 | 190 647 |
| Богд сум | 234 347 | 7 087 | 6 879 | 5 613 | 42 659 | 172 109 |
| Бөмбөгөр сум | 255 757 | 10 008 | 5 726 | 255 | 65 247 | 174 521 |
| Бууцагаан сум | 290 991 | 10 775 | 7 424 | 2 112 | 71 865 | 198 815 |
| Галуут сум | 249 715 | 16 367 | 29 610 | 80 | 110 448 | 93 210 |
| Гурванбулаг сум | 138 641 | 10 249 | 14 268 | 47 | 71 340 | 42 737 |
| Жаргалант сум | 142 369 | 10 106 | 25 017 | 3 | 60 815 | 46 428 |
| Жинст сум | 207 474 | 6 151 | 2 241 | 2 328 | 43 574 | 153 180 |
| Заг сум | 143 769 | 8 663 | 9 157 | 195 | 65 996 | 59 758 |
| Өлзийт сум | 251 001 | 14 064 | 14 313 | 332 | 84 047 | 138 245 |
| Хүрээмарал сум | 191 596 | 8 863 | 6 259 | 501 | 84 812 | 91 161 |
| Шинэжинст сум | 187 412 | 2 017 | 183 | 4 995 | 20 572 | 159 645 |
| Эрдэнэцогт сум | 167 801 | 10 514 | 44 184 | | 61 761 | 51 342 |

| | | | | | | |
|------|-----------|---------|---------|--------|-----------|-----------|
| Нийт | 4 236 321 | 159 143 | 213 809 | 49 660 | 1 244 588 | 2 569 121 |
|------|-----------|---------|---------|--------|-----------|-----------|

Улсын хэмжээнд манай аймаг нийт малын тоогоороо 5 дугаарт орж, ямаан сүргийн тоогоороо 1 дүгээрт, тэмээн сүргийн тоогоороо 2 дугаарт орж байна.

Баянхонгор аймгийн 2017 оны 01 сарын том малын зүй бус хорогдлын мэдээ

| Сумын нэр | Оны эхний мал | Хувь | Хорогдсон мал | | | | | Өвчнөөр хорогдсон мал | | | | | Хорогдсон хээлтэгч | | | | | | | |
|-------------|---------------|------|---------------|--------|------|------|------|-----------------------|--------|-------|------|------|--------------------|--------|------|-------|------|------|------|------|
| | | | Бүгд | Үүнээс | | | | Бүгд | Үүнээс | | | | Бүгд | Үүнээс | | | | | | |
| | | | | Тэмээ | Адуу | Үхэр | Хонь | | Ямаа | Тэмээ | Адуу | Үхэр | | Хонь | Ямаа | Тэмээ | Адуу | Үхэр | Хонь | Ямаа |
| Баянхонгор | 169 373 | 0.2 | 322 | | 8 | 15 | 123 | 176 | 5 | | | | 5 | | 139 | | | 5 | 50 | 84 |
| Баацагаан | 357 184 | 0.0 | 0 | | | | | | 0 | | | | | | 0 | | | | | |
| Баянбулаг | 116 501 | 0.1 | 106 | | 3 | 18 | 37 | 48 | 0 | | | | | | 11 | | | | 4 | 7 |
| Баянговь | 209 971 | 0.0 | 0 | | | | | | 0 | | | | | | 0 | | | | | |
| Баянлиг | 223 050 | 0.0 | 0 | | | | | | 0 | | | | | | 0 | | | | | |
| Баян-Овоо | 250 576 | 0.4 | 1100 | | 41 | 139 | 484 | 436 | 0 | | | | | | 232 | | 9 | 34 | 86 | 103 |
| Баян-Өндөр | 187 044 | 0.0 | 0 | | | | | | 0 | | | | | | 0 | | | | | |
| Баянцагаан | 261 749 | 0.0 | 0 | | | | | | 0 | | | | | | 0 | | | | | |
| Богд | 234 347 | 0.0 | 0 | | | | | | 0 | | | | | | 0 | | | | | |
| Бөмбөгөр | 255 757 | 0.0 | 0 | | | | | | 0 | | | | | | 0 | | | | | |
| Бууцагаан | 290 991 | 0.0 | 89 | | | | 6 | 83 | 0 | | | | | | 0 | | | | | |
| Галуут | 249 715 | 0.1 | 260 | | 48 | 62 | 57 | 93 | 0 | | | | | | 51 | | 6 | 12 | 15 | 18 |
| Гурванбулаг | 138 641 | 0.3 | 479 | | 49 | 62 | 200 | 168 | 0 | | | | | | 36 | | 6 | 4 | 12 | 14 |
| Жаргалант | 142 369 | 0.0 | 0 | | | | | | 0 | | | | | | 0 | | | | | |
| Жинст | 207 474 | 0.0 | 0 | | | | | | 0 | | | | | | 0 | | | | | |
| Заг | 143 769 | 0.0 | 35 | | 1 | 3 | 9 | 22 | 0 | | | | | | 0 | | | | | |
| Өлзийт | 251 001 | 0.1 | 139 | | 3 | 2 | 17 | 117 | 0 | | | | | | 0 | | | | | |
| Хүрээмарал | 191 596 | 0.0 | 0 | | | | | | 0 | | | | | | 0 | | | | | |
| Шинэжинст | 187 412 | 0.0 | 0 | | | | | | 0 | | | | | | 0 | | | | | |
| Эрдэнэцогт | 167 801 | 0.1 | 174 | | 15 | 36 | 64 | 59 | 0 | | | | | | 0 | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|--|-----------|-----|------|---|-----|-----|-----|------|---|---|---|---|---|---|-----|---|----|----|-----|-----|
| | 4 236 321 | 0.1 | 2704 | 0 | 168 | 337 | 997 | 1202 | 5 | 0 | 0 | 0 | 5 | 0 | 469 | 0 | 21 | 55 | 167 | 226 |
|--|-----------|-----|------|---|-----|-----|-----|------|---|---|---|---|---|---|-----|---|----|----|-----|-----|



ОРОН НУТГИЙН ОРЛОГО, БАНК

2017 оны 01 сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 560.5 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 157.9 сая төгрөгөөр буюу 39 хувиар өссөн байна. 2017 оны эхний 01 сарын байдлаар нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Баян-овоо, Баянлиг, Баянцагаан, Баацагаан, Бууцагаан сумууд давуулан биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: НӨАТатвар 11,7 сая төгрөг, түгээмэл тархацтай АМАТ 0,2 сая төгрөг, ЦХТА орлого 4,5 сая төгрөг, ҮХЭХ борлуулсны 1,7 сая төгрөг, хог хаягдлын хураамж 5,0 сая төгрөг, газрын төлбөр 2,6 сая төгрөгөөр тус тус тасарч, ИОТТХ 0,4 сая төгрөг, нохойн татвар 0.3 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 13,3 сая төгрөг, бууны татвар 1.4 сая төгрөг, ус ашигласны төлбөр 0,9 сая төгрөг, ҮХЭХ-н татвар 9,6 сая төгрөг, ААНБ-ын орлогын албан татвар 4,3 сая төгрөг, төгрөгөөр тус тус давуулан биелэлээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 2.0 хувь, нэмүү өртгийн албан татвар 4,0 хувь, ЦХТА орлого 56 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 1,0 хувь, хүү торгууль 9,0 хувь бусад төлбөр хураамж 28,0 хувийг эзэлж байна.

2017 оны 01 дугаар сарын эцэст иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 63390.9 сая төгрөг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 124229.1 сая төгрөгт хүрчээ. Чанаргүй зээл 2763.5 сая төгрөгт хүрсэн нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.3 хувийг эзэлж байна.



ЭРҮҮЛ МЭНД

2017 оны 01 сарын байдлаар аймгийн хэмжээнд 131 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 27 төрөлтөөр буурсан байна. Нийт төрсөн эхийн 93,0 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын, сумын эмнэлэгт 7,0 хувь нь төржээ. Нялхасын эндэгдэл эхний 01 сарын байдлаар 3 гарчээ.

01 сарын байдлаар архаг болон цочмог халдварт өвчний гаралтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад салхин цэцэг 14, тэмбүү 8, хүйтэн 7, арьсны мөөгөнцөр 10, сүрьеэ 5, трихомониаз 40, халдварт гепатит 4, гахай хавдар 1 тохиолдлоор тус тус гарсан байна.

Аймгийн хэмжээнд эхний 01 сарын байдлаар нас баралтын 33 тохиолдол бүртгэгдсэний 21,0 хувь нь эмнэлэгт нас барснаас 6.0 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс буурсан байна.

Түргэн тусламжийн дуудлага өнгөрсөн оны 01 сард 1290 байсан бол энэ оны эхний 01 сарын байдлаар 1784 болж 494 дуудлага буюу 28 хувиар өссөн байна.



АЖ ҮЙЛДВЭР

2017 оны 01 сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 678,5 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 210,4 сая төгрөгөөр буюу 23,7 хувиар буурсан.

Жилийн эцсийн байдлаар аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг авч үзэхэд урьд оны мөн үеэс нарийн боов 2,9 тн-оор, талх 3,7 тн-оор, дулаан 9,0 тн-оор өсч, нүүрс 0,5 тн-оор, хоормог 0,5 мян.литр, түгээсэн цэвэр ус 3,0 мян.м3-ээр тус тус буурсан байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт өссөн дүнгээр /мян.төг/

| Нийт борлуулалт /мян.төг/ | Нэгдүгээр сар | | |
|---------------------------|-----------------|-----------------|-----------------|
| | 2016 | 2017 | 2017.01/2016.01 |
| | 888884.1 | 678469.7 | 76.3 |

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /өссөн дүнгээр/

| Бүтээгдэхүүний нэрс | хэмжих нэгж | Нэгдүгээр сар | | |
|---------------------|-------------|---------------|------|-----------------|
| | | 2016 | 2017 | 2017.01/2016.01 |
| Нүүрс | мян.тн | 6.2 | 5.7 | 91.9 |
| Дулаан | мян.Гкал | 28.4 | 37.4 | 131.6 |
| Нарийн боов | тн | 7.5 | 10.4 | 138.6 |
| Талх | тн | 9.6 | 12.3 | 128.1 |
| Түгээсэн цэвэр ус | Мян.м3 | 26.6 | 23.6 | 88.7 |
| Тараг | Мян.л | 0.3 | 0.3 | 100 |
| Хоормог | Мян.л | 1 | 0.5 | 50 |



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

2017 оны эхний 01 сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 2066.7 сая төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 427.2 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 166.8 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 44.7 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 1.0 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 32.1 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 32.0 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 5.3 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 1.9 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 26.2 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээний эмийн зардалд 82.6 сая төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 23.6 сая төгрөг тус тус олгожээ.

Нийгмийн халамжийн сангаас 2017 оны 01 сард 1612 хүнд 248,1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй 1561 эхчүүдэд 63,3 сая төгрөг, алдар цолтой 8 ахмадуудад 1,1 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн бол Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж 63 хүн 8,4 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж/ 38 хүн 3,7 сая төгрөг тус тус зарцуулсан байна.



ГЭМТ ХЭРЭГ

2017 оны эхний 01 сард аймгийн хэмжээнд нийт 55 хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23 нэгжээр буюу 71.9 хувиар өссөн. Хэргийн илрүүлэлт 66,6 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 33,3 пунктээр өсчээ. Хэргийн гаралт 5 суманд буурч, 7 суманд өсөж, 2 суманд ижил түвшинд байна. Гэмт хэрэгт 20 хүн холбогдон шалгагдсан ба 34,5 хувь нь 18-29 насны залуучууд, 18 буюу 32,7 хувийг ажилгүй иргэд байгаа нь анхаарал татахуйц байна. Гэмт хэргийн улмаас 58 иргэн хохирч 3 хүн нас барж, 35 хүн гэмтсэн байна. 74,8 сая төгрөгийн хохирол учирснаас 45,8 сая төгрөгийг төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 61,3 хувьтай байна.

Хүн амь 100 хувь, бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэрэг 31,2 хувь, өмчийн хулгай 27,2 хувь, иргэдийн өмчийн хулгай 80 хувь, тээврийн хэрэгслийн хулгай, залилан, танхай, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын эсрэг гэмт хэрэг тус тус 100 хувь бусад гэмт хэрэг 66,6 хувь өссөн байна.

Харин дээрэм 5 нэгжээр буюу 71.4 хувь буурч, залилан 1 нэгжээр буюу 20 хувь өсч, малын хулгай, булаалтын гэмт хэрэг 6 нэгжээр буюу 16.6 хувиар буурчээ. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал нь хөнгөн гэмт хэрэг 180 бүртгэгдэж 6.5 хувиар өссөн бол хүндэвтэр гэмт хэрэг 159 бүртгэгдэж 0.6 хувь, хүнд гэмт хэрэг 12 бүртгэгдэж 58.2 хувиар буурч, онц хүнд гэмт хэрэг 5 бүртгэгдэж 25 хувиар өсчээ.



ҮНЭ ТАРИФ

2017 оны 01 дүгээр сард өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх оны мөн үеийнхээс 4,5 хувиар, өмнөх сарынхаас 2,9 хувиар өссөн байна. Хүнсний бараа ундаа усны бүлгийн дүн 2017 оны 01 дүгээр сард өмнөх сарынхтай харьцуулахад 11,4 хувиар, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисийн бүлгийн дүн 0,9 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн дүн 0,9 хувиар эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн дүн 14,4 хувиар, тээврийн үйлчилгээний бүлгийн дүн 1,8 хувиар өсч, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн дүн 5,8 хувиар буурсан нь ерөнхий индекс 4,5 хувиар өсөхөд нөлөөлсөн байна.

Баянхонгор 2017 оны 01 дүгээр сарын инфляц

| Барааны бүлгээр | 2017-01 2016-01 | 2017-01 2016-12 |
|---|--------------------|--------------------|
| ЕРӨНХИЙ ИНДЕКС | 104.5 | 102.9 |
| 01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА | 111.4 | 107.9 |
| 02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС | 100.9 | 100.2 |
| 03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ | 100.3 | 102.2 |
| 04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ | 94.2 | 100.1 |
| 05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА | 100.9 | 100.2 |
| 06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 114.4 | 100.0 |
| 07. ТЭЭВЭР | 101.8 | 100.7 |
| 08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 101.5 | 100.0 |
| 09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ | 118.8 | 100.0 |
| 10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| 11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ | 118.9 | 100.0 |
| 12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ | 102.4 | 101.2 |

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Хаяг: АЗДТГазар 303, 305 тоот
Холбоо барих утас: 70442081, 70442403

И мэйл хаяг: bayankhongor@nso.mn

Вэб сайт: www.nso.mn сайтын Баянхонгор /Статистикийн хэлтэс-Бюллетень/,
bayankhongor.gov.mn сайтын Статистик мэдээ

